БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр Дугаар А/155 Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны V хуралдааны 04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан аймгийн Нэгдсэн эмнэлгийн Доторын тасгийн их засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2022 оны 02 дугаар сарын сарын 21-ий өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Булган аймгийн "Тана-Орд" ХХК-тай 193 820 360 /нэг зуун ерэн гурван сая найман зуун хорин мянга гурван зуун жар) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Г.Ганбаатар)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Г.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Тана-Орд" ХХК-ийн захирал (Г.Цэцэгмаа)-д даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг 2022 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Захирамж-2022

6300210155

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 сарын 04 өдрийн 04/144 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах эзэн
2	Магадлашгүй ажил	3 261 337	Г.Ганбаатар
3	Захиалагчийн албаны зардал	3 261 337	Г.Ганбаатар
4	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1 630 668	Г.Ганбаатар
5	Алданги	хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлын 50 хоног	Г.Ганбаатар
7	Гүйцэтгэлийн баталгаа гаргаж гэрээ байгуулах дүн	9 691 018	Г.Ганбаатар
8	Зураг төсвийн үнэ	6 000 000	Г.Ганбаатар